**АРД ДААТГАЛ ХК**

| | | Хэрэгжилт | Тайлбар | Оноо | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ** | | | | | |
| 1 | *1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.* | Биелүүлж ажилладаг | ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗНБДаргын үйл ажиллагааны журмуудын дагуу зохицуулдаг | 2 | 2.8% |
| 2 | *1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.* | Биелүүлж ажилладаг | Залгамж халааны бодлого ТУЗ-р батлуулж хэрэгжүүлж эхэлсэн | 2 | 2.8% |
| 3 | *1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.* | Биелүүлж ажилладаг | ТУЗ-ийн гишүүдийн мэдээллийг өөрсдийн цахим хаяг, сошиал сувгуудаар мэдээллэдэг, Жилийн үйл ажиллагааны тайланд тусгаж ажилладаг, ТУЗ-ийн гишүүдийн хувьцаа эзэмшлийн мэдээлэл МХБ-ийн вебсайтад мэдээллийг нь оруулж ажилладаг. | 2 | 2.8% |
| 4 | *1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.* | Биелүүлж ажилладаг | ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон хороодын үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд тус тусын журамтай | 2 | 2.8% |
| 5 | *1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.* | Биелүүлж ажилладаг | Компанийн засаглалын сургалтанд хамруулдаг бөгөөд холбогдох дүрэм журмуудтай танилцуулж чиглүүлж өгдөг. Мөн жил бүр ТУЗ-ийн гишүүд удирдах ажилтнуудыг хамруулан сургалт, ретрит зохион байгуулан мэдээ мэдээлэл, сургалтанд тогтмол хамруулдаг | 2 | 2.8% |
| 6 | *1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.* | Биелүүлж ажилладаг | ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмын хүрээнд үүрэг хариуцлагыг тодорхойлж өгсөн байдаг | 2 | 2.8% |
| **ДҮН** | | | | **12** | **17%** |
| **ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ** | | | | | |
| 7 | *2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.* | Хэсэгчлэн хэрэгжүүлдэг | ТУЗ-ийн гишүүдийн 1/3 хараат бус гишүүд ажилладаг бөгөөд хороодын даргаар хараат бус гишүүд ажиллаж байна. | 2 | 2.8% |
| 8 | *2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хурал компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.* | Биелүүлж ажилладаг | Аудитын хороо нь ТУЗ-р батлагдсан хорооны журмын дагуу үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хорооны даргаар ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн ажиллуудаг бөгөөд 2/3 нь хараат бус гишүүд ажилладаг. Аудитын хорооны гишүүдийн санал хүсэлтийн дагуу удирдлагын багаас хурлад оролцох шаардлагатай үед оролцдог | 2 | 2.8% |
| 9 | *2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшуулын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшуулын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хурал гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.* | Биелүүлж ажилладаг | ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороотой бөгөөд ТУЗ-р батлагдсан хорооны журмын дагуу үйл ажиллагаа явуулдаг. Хорооны даргаар ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн ажиллуудаг бөгөөд 2/3 нь хараат бус гишүүд ажилладаг бөгөөд хорооны гишүүдийн санал хүсэлтийн дагуу удирдлагын багаас хурлад оролцох шаардлагатай үед оролцдог. Тус хороо нь тусдаа журамтай бөгөөд компанийн цалингын бодлого мөн хэрэгжиж ажилладаг болно. | 2 | 2.8% |
| 10 | *2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.* | Биелүүлж ажилладаг | ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороотой бөгөөд ТУЗ-р батлагдсан хорооны журмын дагуу үйл ажиллагаа явуулдаг. Хорооны даргаар ТУЗ-ийн дарга бус, хараат бус гишүүн ажиллуудаг бөгөөд 2/3 нь хараат бус гишүүд ажилладаг бөгөөд хорооны гишүүдийн санал хүсэлтийн дагуу удирдлагын багаас хурлад оролцох шаардлагатай үед оролцдог. 2023 онд Залгамж халааны бодлого ТУЗ-р батлуулан ажиллаж эхэлсэн. | 2 | 2.8% |
| 11 | *2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг, үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.* | Биелүүлж ажилладаг | ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Засаглал, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороо, Санхүү, эрсдэл хөрөнгө оруулалтын хороод өөр өөрсдийн журам чиглэлийн хүрээнд үйл ажиллаа явуулдаг | 2 | 2.8% |
| **ДҮН** | | | | **10** | **14%** |
| **ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ** | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | *3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.* | Биелүүлж ажилладаг | Олон нийтэд мэдээлэл хүргэх үйл ажиллагааны журамыг баталж мөрдөж ажиллаж байгаа бөгөөд улирал, жилийн эцсийн тайлан, аудитлагдсан тайлан, бусад цаг үеийн мэдээллийг компанийн албан ёсны болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсуудаар дамжуулан олон нийтэд тогтмол мэдээлэлж ажиллаж байна | 2 | 2.8% |
| x | *3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.* | Биелүүлж ажилладаг | Олон нийтэд мэдээллийг ил тод нээлттэй хүргэдэг бөгөөд цаашид шинээр батлагдсан засаглалын кодекс болон МХБ-ийн вебсайтаар дамжуулан “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн тайланг тайлагнаж байгаа бөгөөд бусад КЗК-той холбоотой дотоод дүрэм журам, заавар, бодлогыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлэлдэг. | 2 | 2.8% |
| 14 | *3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтуудаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.* | Биелүүлж ажилладаг | Компанийн санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу тайлагнадаг бөгөөд СЗХ-ны нэмэлт тайлангуудыг тогтмол тайлагнан олон нийтэд мэдээлэлж ажилладаг. Санхүүгийн бус тайланд КЗК-ын хүрээнд тусгах мэдээллүүдийг тусган тайлагнадаг | 2 | 2.8% |
| **ДҮН** | | | | **6** | **8%** |
| **ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО** | | | | | |
| 15 | *4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.* | Биелүүлж ажилладаг | Аудитын хорооны журмын 4.1.1 - 4.1.3 дах заалтуудад хөндлөнгийн аудитыг сонгох, тавигдах шаардлага, эрх үүргийг нь хангах, төлөх хөлсний хэмжээг тогтоож ТУЗ-д танилцуулах, ажлын гүйцэтгэлийг дүгнэх, гэрээ байгуулах, цуцлах, хараат бус аудиторын дүгнэлт, тайланг хүлээн авч компанийн үйл ажиллагаанд хяналт тавих зэрэг бүхий л шаардлагатай асуудлуудыг тусгасан. | 2 | 2.8% |
| 16 | *4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.* | Биелүүлж ажилладаг | Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд өгч байгаа. | 2 | 2.8% |
| 17 | *4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.* | Биелүүлж ажилладаг | Компанийн жилийн тайланд зохих мэдээллийг тусгаж олон нийтэд мэдээлэлж ажилладаг бөгөөд бусад сувгуудаар мэдээллийг өгч ажилладаг | 2 | 2.8% |
| **ДҮН** | | | | **6** | **8%** |
| **ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА** | | | | | |
| 18 | *5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.* | Биелүүлж ажилладаг | Компани эрсдэлийн удирдлагын газартай бөгөөд чиглэл бүрээр тус тусын журмын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Эрсдэлийн тайланг улирал бүр гарган ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, эрсдэл хөрөнгө оруулалтын хороонд танилцуулан зөвлөмж авч ажилладаг | 2 | 2.8% |
| 19 | *5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонхи нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.* | Хэсэгчлэн хэрэгжүүлсэн | ТУЗ-ийн дэргэдэх Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороотой бөгөөд чиглэлийн хүрээнд батлагдсан журам бодлогын хүрээнд үйл ажиллагаа явуулж, дотоод гадаад эрсдлүүдийг судалж эрсдэлийн тайланд дүгнэлт, зөвлөмж өгч ажилладаг. Цаашид шинэчилсэн КЗК-ын хүрээнд хорооны журмыг шинэчилж батлуулах, хороодын гишүүдийн олонхийг хараат бус болгох, хорооны даргыг хараат бус гишүүн томилох зэрэг ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна | 2 | 2.8% |
| 20 | *5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.* | Биелүүлж ажилладаг | Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд тус мэдээллүүдийн талаар мэдээлэлж ажилладаг | 2 | 2.8% |
| 21 | *5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.* | Биелүүлж ажилладаг | Комплайнс хариуцсан ажилтанг ТУЗ-өөс томилж ажлуулдаг бөгөөд шууд ТУЗ-д тайлагнаж ажилладаг болно. Одоо мөрдөгдөж буй комплайнсын хяналтын заавbooрын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна | 2 | 2.8% |
| **ДҮН** | | | | **8** | **11%** |
| **ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ** | | | | | |
| 22 | *6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.* | Биелүүлж ажилладаг | ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны санал болгосноор ТУЗ-өөр батлуулж ажилладаг бөгөөд 2024 оны ХЭХ-д танилцуулж ажилласан болно. | 2 | 2.8% |
| 23 | *6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.* | Биелүүлж ажилладаг | Компани нь Урамшууллын журмын хүрээнд гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн ажлын гүйцэтгэлийг үнэлж урамшууллын хэмжээг тогтоодог бөгөөд Цалингийн шатлалын хүрээнд цалингийн хэмжээг тодорхойлж ажилладаг бөгөөд цалин, урамшууллын бодлогын баримт бичигтэй болно | 2 | 2.8% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 24 | *6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.* | Биелүүлж ажилладаг | Жилийн үйл ажиллагааны тайланд үйл ажиллагаа болон санхүүгийн голлох үзүүлэлтүүдийг тусгаж тайлагнадаг бөгөөд Гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг бүрэн тусгадаггүй. Хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл тул олгох зарчим, нөхцлийг ХЭХ-д тайлагнаж ажилладаг. | 2 | 2.8% |
| **ДҮН** | | | | **6** | **8%** |
| **ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ** | | | | | |
| 25 | *7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.* | Биелүүлж ажилладаг | 2023 онд ТУЗ-с "Компанийн оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого"-ыг баталж хэрэгжүүлж эхэлсэн | 2 | 2.8% |
| 26 | *7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.* | Биелүүлж ажилладаг | Жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажилласан мэдээ мэдээлэл, нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлуудыг дэлгэрэнгүй тайлагнаж ажилладаг | 2 | 2.8% |
| 27 | *7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэй ажиллуулна.* | Биелүүлж ажилладаг | Бүх оролцогч талуудыг мэдээ мэдээллээр хангах зорилгоор цахим хуудсыг ажиллуулдаг бөгөөд цаашид илүү хөгжүүлэн мэдээ мэдээллийн чанарт анхаарч ажиллахаар төлөвлөгөөт ажлууд эхлүүлээд байна | 2 | 2.8% |
| 28 | *7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.* | Биелүүлж ажилладаг | Компанийн ажилтнуудын санал хүсэлт өгөх, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх асуудлуудыг хөдөлмөрийн дотоод журам, ёс зүйн хорооны журам, урамшуулын журмуудаар зохицуулдаг | 2 | 2.8% |
| **ДҮН** | | | | **8** | **11%** |
| **НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ** | | | | | |
| 29 | *8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.* | Биелүүлж ажилладаг | Ёс зүйн хорооны журмыг баталж мөрдөж ажилладаг бөгөөд энэхүү журмыг сайжруулан ТУЗ, нийт ажилтнууд, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийн ёс зүйн хэм хэмжээг тодорхойлон ТУЗ-өөр батлуулан ажиллахаар боловсруулж байна | 2 | 2.8% |
| 30 | *8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.* | Биелүүлж ажилладаг | Ёс зүйн хорооны журмаар зохицуулж байгаа бөгөөд журмын шинэчилсэн хувилбараар бүх тогтолцоог тодорхой тусгахаар ажиллаж байна. | 2 | 2.8% |
| 31 | *8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.* | Биелүүлж ажилладаг | Ёс зүйн хорооны журмаар зохицуулж байгаа бөгөөд журмын шинэчилсэн хувилбараар авлига, албан тушаалын гэмт хэрэг, сонирхлын зөрчилтэй үүсэхээс урьдчилан сэргийлэх заалтууд тусгагдаж байгаа болно | 2 | 2.8% |
| **ДҮН** | | | | **6** | **8%** |
| **ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ** | | | | | |
| 32 | *9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.* | Биелүүлж ажилладаг | Улирал бүр сошиал сувгуудаар дамжуулан цаг үеийн асуудал тайлангуудыг танилцуулдаг бөгөөд жилийн тайланд дэлгэрэнгүй мэдээллүүдийг тайлант хугацаагаар нэгтгэн цахим хуудас болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэлж ажилладаг | 2 | 2.8% |
| 33 | *9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.* | Биелүүлж ажилладаг | 2023 онд ТУЗ-с "Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр"-ийг баталж ажиллаж байна. Мөн Компанийн www.arddaatgal.mn цахим хуудас, info@arddaatgal.mn, Ard Insurance facebook хуудас, Твитер хаягуудаар дамжуулан мэдээлэл хүргэж солилцож ажилладаг. | 2 | 2.8% |
| 34 | *9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.* | Биелүүлж ажилладаг | ХЭХ-ийг жил бүр хуульд заасан хугацаанд зохицуулах байгууллагаас гаргасан журмуудын хүрээнд зохион байгуулдаг бөгөөд боломжит бүх хэлбэрээр мэдээ мэдээллийг хүргэж, нээлттэй ажилладаг болно | 2 | 2.8% |
| 35 | *9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хавьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.* | Биелүүлж ажилладаг | Компани үйл ажиллагааны чиглэл нэмэлт өөрчлөлт орох, их хэмжээний хэлцэл, дүрмийн өөрчлөлт, нэмж хувьцаа гаргах, халаалслах зэрэг өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлуудыг ХЭХ-р хэлэлцүүлэн шийдвэрлүүдэг бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл хэлэцүүлж байгаа тохиолдолд сонирхлын зөрчилгүй ХЭ-ийн саналаар шийдвэрлэхээр мөрдөж ажилладаг болно | 2 | 2.8% |
| 36 | *9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.* | Хэсэгчлэн хэрэгжүүлдэг | Компани сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тохиолдолд ТУЗ-р хэлэлцүүлэн сонирхлын зөрчилгүй болон хараат бус гишүүдийн саналаар баталгаажуулан ажилладаг бөгөөд Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тус тус тусгасны дагуу тайлагнаж мэдээлэлж ажиллаж байна. | 2 | 2.8% |
| **ДҮН** | | | | **10** | **14%** |
| **НЭГДСЭН ДҮН** | | | | **72** | **100.0%** |

"Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийн тайлан гаргасан: Г. Баярбат
ТУЗ-ийн НБД

"Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийн тайлан үнэн зөвийг баталсан: Г. Цогбадрах
Гүйцэтгэх захирал